



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 09 өдөр

Дугаар А/30

Улаанбаатар хот

Нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулагдах
бүх нийтийн их цэвэрлэгээний хуваарийг
шинэчлэн батлах тухай


Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, гэр болон орон сууцны хорооллын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах таатай орчин, нөхцлийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулагдах бүх нийтийн их цэвэрлэгээний хуваарийг шинэчлэн хавсралт ёсоор баталсугай.

2. Дүүргийн нутаг дэвсгэрт их цэвэрлэгээг зохион байгуулах ажлын хэсэг байгуулж, удирдамж, хуваарь, төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавих, харьяа газар болон аж ахуйн нэгж байгууллага, иргэдийг цэвэрлэгээнд бүрэн хамруулж оролцуулах, үр дүнг тайлагнаж ажиллахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, чиг үүргээр хангаж, бүх нийтийн их цэвэрлэгээний тайлан, дүн мэдээг тухай бүр танилцуулж, ажлаа сурталчилж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/01 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

1110300419

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
 2019 оны 05 сарын 09
 өдрийн А/А/О тушаалын хавсралт



НИИСЛЭЛИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНД БҮХ НИЙТИЙН ИХ
 ЦЭВЭРЛЭГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХУВААРЬ

№	Цэвэрлэгээ зохион байгуулах хугацаа		Хариуцан зохион байгуулах мэргэжилтэн	Апбан тушаал
1	2019 оны 01 дүгээр сарын 26,27	Сар шинийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ.	З.Мөнгөнзул	ТХХУХ-ийн мэргэжилтэн
2	2019 оны 04 дүгээр сарын 27	"Их цэвэрлэгээний 90 минут" Хаврын бүх нийтийн их цэвэрлэгээ.	С.Аригуун	ТХХУХ-ийн Ахлах мэргэжилтэн
3	2019 оны 05 дугаар сарын 25	Зуслан, ногоон бүсийн их цэвэрлэгээ.	Т.Энх-Амгалан	ТХХУХ-ийн мэргэжилтэн
4	2019 оны 06 дугаар сарын 29	Үндэсний их баяр наадам угтсан цэвэрлэгээ, Шарилжгүй Улаанбаатар аян-4 1-р үе шатыг эхлүүлнэ.	С.Аригуун	ТХХУХ-ийн Ахлах мэргэжилтэн
5	2019 оны 07 дугаар сарын 20	Шарилжгүй Улаанбаатар 4 аяны 2 дугаар үе шатыг эхлүүлнэ.	З.Мөнгөнзул	ТХХУХ-ийн мэргэжилтэн
6	2019 оны 08 дугаар сарын 17	Хичээлийн шинэ жилийг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ	С.Аригуун	ТХХУХ-ийн Ахлах мэргэжилтэн
7	2019 оны 10 дугаар сарын 19	Нийслэлийн өдрийн угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ	З.Мөнгөнзул	ТХХУХ-ийн мэргэжилтэн
8	2019 оны 11 дүгээр сарын 16	Хальтиргаа гулгаанаас урьдчилан сэргийлэх бүх нийтийн их цэвэрлэгээ	Т.Энх-Амгалан	ТХХУХ-ийн мэргэжилтэн
9	2019 оны 12 дугаар сарын 14	Шинэ жилийн баярыг угтсан бүх нийтийн их цэвэрлэгээ.	С.Аригуун	ТХХУХ-ийн Ахлах мэргэжилтэн